

Эрдэнэ хамбын хийд

Төв азийн дунд орших Монгол улс нь эртний түүх сойгоор баялаг улсын нэг билээ. Бурханы шашин нь Монгол оронд түгэн дэлгэрэхдээ нүүдэлчдийн өвөрмөц соёл, зан заншил, амьдралын хэв маягийг шингээн өөрийн гэсэн өнгө төрхийг бий болгон хөгжсөөр ирсэн. Шашны дэлгэрэлтийг эхэн, дунд, хожуу үе гэсэн гураван хэсэгт авч үздэг үүнтэй холбогдолтой нэгэн хийд байдаг нь одоогийн Булган аймгийн Рашаант сумын нутагт орших Хөгнө Хан уулын Өнгөн хийд билээ.

Бурханы шашны эхэн болон хожуу дэлгэрэлтэй холбоотой энэ хийд нь 2 удаа нураалгасан түүхтэй 9-р зууны сүүл үе 10-р зууны эхэн үед энэ хийдийг анх босгоон гэж үздэг ба тухайн үед болсон Төвдийн нэгэн үйл явдалтай холбогддог.

Төвдийн оронд Бурханы шашин дэлгэрээд хэвчлэл байтал Лэнцадм нэрт хаан ширээнд заларч удалгүй шашныг устган үгүй хийсэнд Лхаламбалдорж хэмээхч хааныг устгаад улмаар зүгтэн Монгол орноо ирж Хан уулан дахь энэ хийдэд бууж байсан байдаг. Хожим нь аравдугаар жарны хар хугаана жил, Мин улсын Сүмун хааны 40-р он буюу 1612 онд Халхын Эрдэнэ цорж лам "Жамсран" бурхныг Монгол орноо залан ирсэнд Халхын Түшээг Хан, Өндөр гэжсэн Занабазарын эцэг Гомьбордорж өөрийн хөшүүнд харьяалагдах Хан уулын хийдэд залж, өөрийн харьяалаас 80 өрх айл шавь болгон өргөж, Эрдэнэ цорж лам Төвдийн Лхас хотын Голата ордныг дууриалган уул өгсүүлэн арав орчим хийд барьсан байна. Гол дуган нь Жигжидийн Жанхар буюу Ямандага бурханы хот мандагыг дуурайлган 64 тасалгаа бүхий өвөрмөц зохион байгуулалттай сүмийг босгожээ. Арав орчим дуган сүм бүхий энэ хийд нь, Хан уулын ой мод, рашаан ус жигдэрсэн үзэсгэлэнт аманд






байрладаг юм.

1688 онд эхэлсэн Халх Ойрдын дайны хөлд сүйрэн ойрдын цэрагт лам нараа Хөгүүлэн алуулж бүх сүн хийдээ устгуулж бүрэн сүйрсэн байна. Энэ хийдийн үлдэг хоцорсон туурь нь "Өгөг хийд" хэмээн алдаршжээ 1699 оноос эхлэн уулын дорд ямааг шилүүлэн дахин хийдээ сэргээн барьсан нь Хөлий хийд хэмээн алдарсан билээ. Эрдэнэ цорж ламын хойд дүүрүүд эрдэнэ хамба хутагт хэмээн залагдаж халхын алдартай лам нарын нэг болсон төдийгүй халхын 13 тамгатай хутагтын нэгээр өргөмжлөгдөж, Их Шавийн голын долоон цоржын нэг байсан билээ. Тус хийд нь Монголд цөөн байсан улааны ёсыг баримтлагч тарни болон бясалгал голчлон сайжсан орон хийд байсан гэдэг. Эрдэнэ Богдын Их Шавьд хамаарагддаг хийд байсан. Тус хийдийн лам нар тарни бүтээл, Жод лүүжин, Намба бясалгал гал сум, Монгол хийцийн гол сум, Монгол хийцийн дугуй жижиг хоёр сүн, хадаг уулын дунд чулуугаар барьсан тахилгын сүм, түүний шар шавар хөх тоосго чулуугаар хослуулан барьсан сүм дуганууд байжээ.

хамбын хийд нь "Дамчойжанчүүлэн" буюу дээдийн ном Бодь хутгийн хийд гэсэн нэртэй, Богдын Их Шавьд хамаарагддаг хийд байсан. Тус хийдийн лам нар тарни бүтээл, Жод лүүжин, Намба бясалгал гал сум, Монгол хийцийн гол сум, Монгол хийцийн дугуй жижиг хоёр сүн, хадаг уулын дунд чулуугаар барьсан тахилгын сүм, түүний шар шавар хөх тоосго чулуугаар хослуулан барьсан сүм дуганууд байжээ.



1937 оныг хүртэл номын хувилгаан чадал эзэмшсэн байнгын 50 орчим лам нартай, хурлын 8 дуган, 8 суваргатай, 2 жастай хийд байж. Догшин улаан сахиус гэх Жамсран бурхныг өдөр болгон тахин сахиусны өмнөөс чойжин буулгадаг. Ийдэр эргэж, өдөр шөнийн алинд ч Таван хан сахиусыг тахидаг аж. Жамсран бурханы тахилга нь бусад хүрээ хийдээс элгэр тахилгатай гэхчлэн нэгэн сайхан хийд байсныг, 1937 оны цаг төрийн үймээнд эрдэм ном, цол мөндөг бүхий лам нараа буудуулан сүм хийдээ нураалтан дахин хавджээ. Олон жилийн түүхтэй, баян тансаг тавил шүтээнтэй, хөрөнгө чинээ ихтэй энэ хийдээс хэдэн чулуун хана, шавар хэрэм, хоёр жижигхэн сүм үлдэж хоцорсон нь харамсалтай. Гэвч 1991 оны цагван морин жилд шашин шүтэх эрх чөлөөгөө оломогц нутгийн уугуул иргэн Ц.Даваа нь өөрийн өөмг эцэг Дэндэвийн сууж байсан энэ хийдийг хувийн хүч хөрөнгө, олон түмний хандиваар дахин сэргээж өдгөө хурлын гол дуган, 2 суварга шинээр барьж, хуучин хийдээс хоцорсон Буман Базарсэдын 8 талт жижиг сүм, Дүнмүүр маанийн хүрдний асар хэлбэрийн шавар сүм зэргийг сэргээгээд байна. Урьдын цагт Монголд 6-хан байсан Таван хааны дуганыг сэргээж, тасраад байсан "Таван хаан" сахиусны уншлага, "Ноджинжамсран" бурханы тахилга зэрэг номын үйл ажиллагааг сэргээсэн. Тус хийдийн үйл ажиллагаа улам өргөжиж ойр хотын сүсэгтэн олон хуран чуулах болсон төдийгүй нэр алдартай хутагт хувилгаад ч дараа даравалан мориж, "Догшин сахиусны оронд" мөргөн залбирч, эх болсон 6 зүйл хамаг амыгны тусын тулд хурал ном хүрсаар байна. Тухайлбал: Балбын их Лхарамбалам Алаан Лувсандандар Ринбүчи 2 удаа, Бөмчин Ойдув Ринбүчи 2 удаа, Энэтхэгийн Натчун Чойжин Түлдэням Ринбүчи 4 удаа, 9-р богд лам, Бакула Ринбүчи, Жадор Ринбүчи, Аюма Ринбүчи, Гүрдаваа Ринбүчи, Күмбүмгий сэрдэг гэгээнтэн, Гандантэчигэн хийдийн хамба лам Чойжамц нар Их Хан уулын хийдэд ирж номын буян хайрласан билээ. Хөгнө хан уул нь Монгол улсын тусгай хамгаалалттай байгалийн цогцолбор газарт хамаарагддаг үзэсгэлэнт газар орон юм. Тус хийд байрладаг уулын ам нь хороод, элэг цөс, нүдний Рашаантай төдийгүй уулын тунгалаг булаг умран гардаг билээ. Энэ сайхан байгалийг хамгаалах тал дээр тус хийд нь анхаарч мод тарих, булаг усаа хамгаалах үйл ажиллагааг өөрсдийн болон гадаад дотоодын байгууллагатай хамтран хийж байна. Мөн гадаад дотоодын жуулчдын үзэх дуртай газруудын нэг билээ.



ТАА-н аюоны дарга М. Цэдэндоржийн авч лавч Майдаржав Майдаржав гуайн анхны Бат-Эрдэнэ зүү хийдийн гэсгүй лам



ТЭНГЭР ЗАЯАТ НУТАГ

БУЛГАН АЙМГИЙН РАШААНТ СУМ



УЛААН ШИВЭЭТ 2014